



МҮХАҮТ

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



2023.03.03

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 23.02



ХЗДХЯ–тай Бизнесийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллана


Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим хооронд хамтын ажиллагааг өргөжүүлэх, бизнес эрхлэх хууль, эрх зүйн таатай орчинг бий болгоход төр, хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Санамж бичиг байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, МҮХАҮТ–ын Ерөнхийлөгч О.Амартүвшин нар

(2023.02.03) гарын үсэг зурлаа. Хамтын ажиллагааны хүрээнд МҮХАҮТ–ын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлийн гишүүд бизнес эрхлэх орчинг сайжруулахтай холбоотой Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж буй хуулийн төслүүдийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллахаар тохиролцов.

ДАРААГИЙН НҮҮРЭНД ...>



“СамАвто” компанийн SAZ Le60 автобус Улаанбаатар хотын нийтийн тээвэрт явж эхэллээ



Худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх талаар Эрээн хотын захиргааны төлөөлөлтэй уулзав



МҮХАҮТ–аас Туркийн ард түмэнд туслах хандивын аяныг өрнүүлж, цугласан хандивыг БНТУ–аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүлээлгэн өглөө



“Монгол–Солонгосын бизнес форум” Сөүл хотноо зохион байгуулагдлаа



Дэлхийн экспортын хөгжлийн форумын В2В уулзалтыг МҮХАҮТ зохион байгуулна



Олон улс, улсын чанартай авто зам дагуу аялал жуулчлалын цогцолбор байгуулах 10 байршлыг шинээр зарлана

“EXECUTIVE SUMMIT 2023” гүйцэтгэх дээд удирдлагуудын уулзалт–хэлэлцүүлэг “ӨӨРЧЛӨЛТӨӨР МАНЛАЙЛЪЯ” уриан дор боллоо

МҮХАҮТ–ын Бизнес Академиас бизнесийн салбарын өмнө тулгамдаж байгаа сорилтуудын шийдлийг эрэлхийлж “EXECUTIVE SUMMIT 2023” Гүйцэтгэх удирдлагын дээд уулзалтыг “ӨӨРЧЛӨЛТӨӨР МАНЛАЙЛЪЯ” уриан дор 3 дахь жилдээ (2023.02.09) амжилттай зохион байгууллаа.

стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ, тогтолцоог нэвтрүүлэх, хамтын манлайллын зарчмыг баримтлан сайн туршлагаа хуваалцах, суралцах орчин бүрдүүлэх”–ийг нийт оролцогчиддоо уриаллаа.



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

“СамАвто” компанийн SAZ LE60 автобус Улаанбаатар хотын нийтийн тээвэрт явж эхэллээ

МҮХАҮТ-ын санаачилгаар Улаанбаатар хотын нийтийн тээвэрт Бүгд Найрамдах Узбекистан Улсын “СамАвто” компанийн SAZ LE60 маркийн автобусыг хүлээлгэн өгөх ёслолын ажиллагаа (2023.02.10) боллоо. “СамАвто” компанийн үйлдвэрийн SAZ LE60 маркийн автобус өөрийн чанараа таниулж, нийтийн тээврийн ачааллыг бууруулах асуудалд




хувь нэмрээ оруулах юм. Зургаан мэргэжилтэн үүнд анхаарч, цаг тухай бүрт нь засвар үйлчилгээг тогтмол хийж, Монголын нөхцөлд улам нийцүүлж, дараа дараагийн сайжруулалтыг хийх аж.

“СамАвто” компанийн SAZ LE60 маркийн автобус нь 190 морины хүчин чадалтай, нэг удаад 56 зорчигч тээвэрлэх боломжтой, цонх нь цантдаггүй, шалнаасаа халдаг, Эйр кондишны нэгдсэн системтэй, шатахууны багтаамж нь 150 литр. Төв Азийн автобус үйлдвэрлэлийн зах зээлд “СамАвто” нь гол нийлүүлэгчдийн нэг юм.



Худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх талаар Эрээн хотын захиргааны төлөөлөлтэй уулзав



МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн Эрээн хотын намын хорооны гишүүн, хотын Засаг даргын орлогч Жан Ин Же-тэй (2023.02.10) уулзаж, хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх талаар санал солилцов. Уулзалтаар Эрээн хотын хилийн иргэдийн худалдааны чөлөөт бүсээр болон Эрээн хотын борлуулалтын төвөөр дамжуулан Монголын аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх талаар ярилцав.

Мөн Замын-Үүд- Эрээн боомтоор найман хүний суудалтай хувийн тээврийн хэрэгслийг АТА Карней гэрчилгээтэй гаалиар нэвтрүүлэх, хоёр талын хилийн

хязгаарлалтын бүсэд чөлөөтэй нэвтрүүлэх талаар судлахаар тохиролцлоо. Түүнчлэн, мэдээлэл солилцоог эрчимжүүлж, хууль бус наймаа зэрэг хууль бус бизнесийн үйл ажиллагааг таслан зогсооход хамтран ажиллана.



МҮХАҮТ-аас Туркийн ард түмэнд туслах хандивын аяныг өрнүүлж, цугласан хандивыг БНТУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд хүлээлгэн өглөө



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин БНТУ-ын Элчин сайдын яаманд (2023.02.10) газар хөдлөлтийн улмаас

олон хүний амь нас эрсэдсэнд эмгэнэл илэрхийлж, эмгэнэлийн дэвтэрт гарын үсэг зурав.



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас гамшгийг хохирол багатай даван туулахад нь Туркийн ард түмэнд тусламж, дэмжлэг үзүүлэх санаачилгыг эхлүүлсэн билээ. Энэхүү хандивын аянд МҮХАҮТ болон

бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс эхний ээлжид 46 сая гаруй төгрөгийн бараа бүтээгдэхүүн, бэлэн мөнгөөр нэгдэн оролцсон бөгөөд хандивын аяны хүрээнд цугласан хандивыг энэ үеэр хүлээлгэн өглөө.

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

“Монгол–Солонгосын бизнес форум” Сөүл хотноо зохион байгуулагдлаа



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Бүгд Найрамдах Солонгос Улсад хийж буй албан ёсны айлчлалын хүрээнд “Монгол–Солонгосын бизнес форум” тус улсын ХАҮТ–д зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Солонгос–Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны хорооны дарга Ким Ёнг Хүн, БНСУ–ын Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний яамны худалдаа хариуцсан Орлогч сайд Жонг Дэ Жин болон Монголын талаас 60 компанийн 80 гаруй, Солонгосын талаас 140 гаруй төлөөлөгч оролцов.

Мөн Монгол–Солонгосын бизнесийн байгууллагуудын төлөөлөл ажил хэрэгч уулзалт хийж, БНСУ–ын талаас K bank, KT group, Samsung C&T, Hyundai E&C, Daewoo E&C, Shinhan Financial group, Seol Asan medical center, Seoul National University Hospital, Emart, Highland зэрэг 20 гаруй томоохон компанийн төлөөлөл оролцжээ.



Дэлхийн экспортын хөгжлийн форумын B2B уулзалтыг МҮХАҮТ зохион байгуулна

Олон улсын худалдааны төвөөс (ИТС) жил бүр зохион байгуулдаг томоохон арга хэмжээний нэг болох Дэлхийн экспортын хөгжлийн форум (WEDF)–ын нээлт Женев хотноо (2023.02.15) болж өндөрлөлөө. Энэ оны форум (WEDF)–ийг Монгол Улсын Засгийн газартай хамтран “Ногоон худалдааг төрөлжүүлбэ: Органик, Дижитал, Тогтвортой” сэдвээр энэ оны 6 дугаар сарын 26–29–ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах бөгөөд ЖДҮ, эмэгтэй бизнес эрхлэгчид, залуу бизнес эрхлэгчид, олон улсын байгууллагуудын дуу хоолойг

нэгтгэхээрээ онцлог юм. МҮХАҮТ нь энэхүү форумын үеэр зохион байгуулагдах B2B уулзалтыг хариуцан зохион байгуулах бөгөөд ИТС–ийн Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих “SheTrade” төслийн Монгол Улс дахь салбарыг МҮХАҮТ–ын дэргэд байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



Programme Overview 26 - 29 June			
Monday, 26 June Pre-events Full-day event LLDC Private Sector Preparatory Meeting ↓ Lunchtime Talk BUSINESS CLINICS MEDIA BRIEFINGS EXPORT OPPORTUNITIES TO CHINA WELCOME COCKTAIL	Tuesday, 27 June (MSME Day) WEDF Day 1 OFFICIAL OPENING NETWORKING BREAK MONGOLIA EXHIBITION ONLINE LEARNING OPPORTUNITIES ↓ Lunchtime Talk IN CONVERSATION: SCALING UP YOUTH ENTREPRENEURSHIP IN NEW SECTORS GREEN PITCH COMPETITION: YOUNG ENTREPRENEURS WHO INSPIRE HOST DINNER AND CULTURAL EVENT	Wednesday, 28 June WEDF Day 2 IN CONVERSATION: TRADE MEGATRENDS FOR LLDCS GREEN TRADE ↓ Lunchtime Talk ACCESS TO FINANCE CLOSING SESSION: WHAT NEXT?	Thursday, 29 June Capacity-building day Full-day event CLEAN, LEAN, GREEN: TOWARDS QUALITY ORGANIC PRODUCTS • quality management • organic certification • market linkages • e-commerce training ↓ Lunch break CAPACITY BUILDING (CONTINUED) FIELD VISITS AND TOURISM PACKAGES

Олон улс, улсын чанартай авто зам дагуу аялал жуулчлалын цогцолбор байгуулах 10 байршлыг шинээр зарлана

Орон нутгийн замд өдөрт 13–15 мянган тээврийн хэрэгсэл, 50–60 мянга гаруй зорчигч зорчиж, хоол идэх, дэлгүүрээр үйлчлүүлэх, ариун цэврийн өрөө ашиглахаар 195 мянга гаруй удаа, шатахуун цэнэглэх, дугуй, техник засвар үйлчилгээ ашиглахаар 24 мянган удаа зогсоц хийдэг судалгаа бий. Тиймээс энэ салбарт иргэдийн эрэлт их, нөгөө талаас орон нутгийн зам дагуу хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээ, сонголт, хүрэлцээ муу байгаа тул аялал жуулчлалын цогцолбор

байгуулах шаардлага их байна. Авто зам дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр өнгөрсөн хугацаанд нийт 21 байршлыг зарлаж, гэрээ байгуулсан бөгөөд 5 цогцолбор ашиглалтад бүрэн орсон, 16 цогцолбор 2023 онд ашиглалтад орох юм. Түүнчлэн энэ онд ахин 10 байршлыг шинээр зарлаж, аялал жуулчлалын цогцолбор байгуулах аж.



3-Р САРД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

3 дугаар сарын 5-11

“Монгол - Катар, Монгол - Кувейт” бизнес форум, Доха, Кувейт хот

3 дугаар сарын 7-10

“FoodEx Japan 2023”, Токио хот

3 дугаар сарын 9

Монгол-Сингапурын цахим вебинар

3 дугаар сарын 14-18

Барилга, уул уурхайн олон улсын үзэсгэлэн, Лас вегас хот

3 дугаар сарын 16-22

“Монгол-Австрийн бизнес форум”, Вена хот

3 дугаар сарын 24

“Harvard ManageMentor” сургалт, МҮХАҮТ

7727-7070

